



ДОРНОД АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/02

Чойбалсан

Г Ерөнхий мэргэжилтэн томилох тухай Г

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын дэргэдэх ерөнхий мэргэжилтнүүдийн нэрсийг нэгдүгээр, ерөнхий мэргэжилтнүүдийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ерөнхий мэргэжилтэн тус бүрийг үнэмлэхжүүлэн, мэргэжилтнүүдийн ажилд улирал бүр үнэлгээ өгөхийн зэрэгцээ жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор Эрүүл мэндийн газрын Удирдлагын зөвлөлд хийсэн ажлын тайланг хэлэлцүүлж танилцуулах, шаардлагатай тохиолдолд ерөнхий мэргэжилтнүүдийн үндсэн ажлыг зохицуулан, ажиллах нөхцөл боломжоор хангахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв /Д.Должин /-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс /Ч.Оюунтунгалаг/-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны А/32 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Ч.ОЮУНАА

318420058

Эрүүл мэндийн газрын даргын.....оны
 01...дугаар сарын 14...ны/ний өдрийн
дугаар/дүгээр тушаалын
 нэгдүгээр хавсралт



ЕРӨНХИЙ МЭРГЭЖИЛТНИЙ НЭРС

№	Нэрс	Мэргэжил	Албан тушаал	Зэрэг
1	Пүрэв Баярмаа	Хүүхэд нярайн эмч	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Хүүхдийн тасгийн эрхлэгч бөгөөд Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн	Тэргүүлэх зэрэг, Нийгмийн эрүүл мэндийн магистр
2	Дагвадорж Саранцэцэг	Эх барих эмэгтэй- чүүдийн эмч	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Төрөх, эмэгтэйчүүдийн тасгийн эрхлэгч бөгөөд Эх барихын ерөнхий мэргэжилтэн	Тэргүүлэх зэрэг, Клиникийн профессор, Анагаах ухааны магистр
3	Сосорбурам Ганбат	Мэс заслын эмч	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Мэс заслын тасгийн зөвлөх бөгөөд Мэс заслын ерөнхий мэргэжилтэн	Тэргүүлэх зэрэг, Клиникийн профессор,
4	Сүхбаатар Оюунханд	Халдвартын эмч	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын эмч бөгөөд Халдвартын ерөнхий мэргэжилтэн	Ахлах зэрэг
5	Ёнзог Оюунцэцэг	Дотор,бөөр, гемодиализын эмч	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Дотрын тасгийн Зөвлөх эмч бөгөөд Дотрын ерөнхий мэргэжилтэн	Тэргүүлэх зэрэг, Клиникийн профессор
6	Болдбаатар Ганганцэцэг	Тархвар судлаач, хүний их эмч	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдварын сэргийлэлт, хяналтын албаны дарга	Ахлах зэрэг, Анагаах ухааны магистр

Эрүүл мэндийн газрын даргын.....оны
01.....дугаар сарын 14 ны/ний өдрийн
1102 дугаар/дүгээр тушаалын
хоёрдугаар хавсралт



ЕРӨНХИЙ МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Ерөнхий зүйл:

1.Өвчлөлийн бүтэц,статистик үзүүлэлт дээр үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмжийг Эрүүл мэндийн газрын Удирдлагын зөвлөлд тайлагнах,

2. Төрөлжсөн мэргэжлийн чиглэлээр тулгамдсан онош, эмчилгээнд эцсийн шийдвэр гаргаж, дүгнэлт өгөх,

3.Төр, хувийн хэвшлийн бүх шатны эмнэлэг эмч мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах,

4.Тухайн мэргэжлийн чиглэлээр эмч бэлтгэх, мэргэжил дээшлүүлэхэд санал өгөх, анхан шатны эмнэлгүүдийн эмч, мэргэжилтэнг дагалдуулан сургах,

5.Төрөлжсөн мэргэжлийн чиглэлээр Сум дундын эмнэлэг, өрх, сумын эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төв хоорондын ажлын уялдаа холбоог зохицуулах, үүрэг даалгавар өгөх, хяналт үнэлгээ хийх, зөвлөмж өгч хамтран ажиллах,

6.Аймаг, орон нутгийн хэмжээнд мэргэжлийн чиглэлээр сургалт, зөвлөлгөөн зохион байгуулах,

7.Ерөнхий мэргэжилтний ажлын төлөвлөгөө гарган батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг улирал тутам Эрүүл мэндийн газрын Удирдлагын зөвлөлд хэлэлцүүлэн тайлагнах,

8.Мэргэжлийн дагуу судалгаа шинжилгээний ажлыг хийж, удирдлагыг мэдээллээр ханган ажиллах.

oooOooo